



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 8/02.

Цагаан дэнж

Үндсэн чиглэлийн 2018 оны хэрэгжилт дүгнэн,
2019 оны Үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "а", 18.1.2-ын "е", Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дэх заалтыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит VIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 92.62 хувь буюу хангалттай гэж дүгнэсүгэй.

2. Сумын нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

3. Сумын нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг бүрэн хангуулж хагас, бүтэн жилээр дүгнэж, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд хэлэлцүүлэхийг сумын Засаг дарга /Ц.Төмөрбаатар/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Н.Дэмбэрэл/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЭНХБААТАР

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны
12 дугаар сарын 14-ны өдрийн ээлжит VIII хуралдааны
08/02 тогтоолын хавсралт



ЭРДЭНЭЦОГТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙГ
2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Д/д	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2019 онд хүрэх түвшин, үр дүн	Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Хариуцах байгууллага, албан тушаалтан
1	2	3	4	5	6	7
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГО						
Зорилго: “Эрдэнэцогтын иргэд, Эрдэнэцогтын баялаг” зарчмыг удирдлага болгож, иргэдээ бүх талаар системтэй хөгжүүлнэ.						
А. Хүний хөгжил						
1	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дэх заалт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр	Хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, эрэлт нийлүүлэлттэй уялдуулан иргэд, залуучуудад мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтуудыг зохион байгуулж, мэргэжил эзэмших, ажлын байртай болгоход дэмжлэг үзүүлж хамтран ажиллах	Зөвлөгөө -120 хүн, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт -20 хүн хамрагдсан байна	140 хүнд хүрч ажиллана	Төсөл хөтөлбөр Нөөц хөрөнгө	Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Хөдөлмөр эрхлэлт нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
2	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дахь заалт	Насан туршийн боловсролын нэгжээр дамжуулан 18-35 насны бичиг үсгийн боловсролгүй залуучуудад бичиг үсгийн боловсрол олгох аян өрнүүлж, эрүүл аж төрөх дадал хэвшилд сургах	Бичиг үсгийн боловсролгүй 10-аас доошгүй залуучуудыг хамруулж, 400 хүнд амьдрах ухааны сургалт хийнэ	Иргэдийн боловсролын түвшин дээшилнэ.	Сургуулийн төсөв, төсөл хөтөлбөр	Нийгмийн бодлогын мэргэжилтэн Насан туршийн боловсролын менежер
4	Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол	Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлж, хариуцлагатай мэргэшсэн тогтвортой төрийн албыг бүрдүүлнэ	Төрийн албан хаагчдын мэргэшил ур чадвар нэмэгдэн, сахилга хариуцлага сайжирснаар	ТАТХууль, Засгийн газрын 258 дугаар тогтоолын хэрэгжилт хангагданана	Байгууллагын төсөв	Засаг даргын Тамгын газрын дарга
5	Сумын Засаг даргын	“Шинэ хот айл” хөтөлбөрийг	Шинэ хот айлын тоог	Мал аж ахуйн	Малчдын	Мал эмнэлэг үржлийн

1	2	3	4	5	6	7
	үйл ажиллагааны 1-4 дахь заалт	хэрэгжүүлж, жагсаалтанд тусгагдсан 9 ажлыг үргэлжлүүлэн нийтийг хамруулах	тоог урьд оноос өрхөөр нэмэгдүүлнэ	бааз суурь нэмэгдэнэ	идэвх санаачлага, үйл ажиллагааны үр дүнд	тасаг Багийн Засаг дарга
6	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллааны хөтөлбөрийн 4 дэх заалт	Хүн ам бүлгүүдийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	Залуучуудын хөгжлийг дэмжих, "Жендерийн эрх тэгш байдлыг хангах" Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажилласнаар	Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг 60 хувьд хүргэнэ	Сумын Засаг даргын нөөц хөрөнгө	Нийгмийн бодлогын мэргэжилтэн Залуучуудын холбоо
7	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллааны хөтөлбөрийн 20 дахь заалт	Оюутан сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Журмын шалгуур хангасан оюутныг хамруулснаар	Орон нутагт шаардлагатай чадварлаг мэргэжилтэн бэлтгэгдэнэ	Оюутны хөгжлийн зээл, УИХ-ын гишүүний тэтгэлэг	Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Боловсрол соёл, урлагийн газар, Нийгмийн бодлогын хэлтэс
8	Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-3 дахь заалт	"Цагийн менежмент" бүх салбарт цаг хугацааны үнэ цэнэ сургалт зохион байгуулж бүх нийтэд хэвшмэл үйл ажиллагаа болгох	Цагийн менежментийг сайжруулах сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулна.	Бүх нийтээр цаг баримтлах зарчимд суралцан, хэвшил болгоно	Нөөц хөрөнгө, хуримтлал	Ажлын хэсэг Байгууллагын дарга, эрхлэгчид
9	МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.5 дахь заалт	"Би ирээдүйн баялаг бүтээгч" хүүхдийн экспо үзэсгэлэнд хүүхдүүдийг оролцуулах	Үзэсгэлэнд оролцсон хүүхдийн тоогоор	Хүүхэд бүр амьдрах арга ухаанд суралцан хөдөлмөрийн зөв дадалтай болно	Сургуулийн төсөв	Сургуулийн захирал, Нийгмийн бодлогын мэргэжилтэн
10	МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.5 дахь заалт	"Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, 2019 оныг "Хүүхэд хамгаалал өв тэгш	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90- с дээш хувьтай хэрэгжүүлснээр хувьд хүргэнэ	Хүүхэд эрүүл аюулгүй орчинд амьдрах сурч хөгжих нөхцлийг	Сумын Засаг даргын нөөц хөрөнгө	Нийгмийн бодлогын мэргэжилтэн Хамтарсан баг Сургуулийн захирал

1	2	3	4	5	6	7
		хүмүүжлийн жил” ийн төлөвлөгөө боловсруулан ажиллах гарган ажиллах		бүрдүүлж, хүмүүжил төлөвшилд эерэг хандлагууд бий болно үндсэн үзүүлэлт сайжирна		Эрүүл мэндийн төв
Б.Боловсрол						
Зорилго: Боловсролын байгууллагын сургалтын чанарыг сайжруулж, чанарын үзүүлэлтээр аймагт тэргүүлэхийг зорино.						
11	сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 9 дэх заалт	Сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгад их засвар хийх	Их засварыг чанартай гүйцэтгэж барилгын зүүн жигүүрийг ашиглалтанд оруулж, гэр барьж өвөлждөг байдлыг зогсоох.	Барилгыг бүхэлд нь ашиглах, гэрт цэцэрлэгийн хүүхэд хүмүүждэг байдлыг арилгах	Орон нутгийн төсөв 150.0 сая	Аймаг, сумын Засаг дарга
12	Аймаг, сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 10 дахь заалт	Сургуулийн өмнөх боловсролд хамран сургалтын түвшинг ахиулах	90-с дээш хувьд хүргэнэ	Урьд оны түвшнээс 2 хувиар нэмэгдүүлнэ	Байгууллагын төсөв	Цэцэрлэгийн эрхлэгч
13	Эрдэнэцогт сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр 1.8	Сургалтын чанарт ахиц гаргах, заах арга зүйг дээшлүүлэх жилийн хүрээнд УБ хот, ӨВ, Хөвсгөл аймгуудын сургуулиудад туршлага судлах захиалгат сургалтанд хамрах/ 1,3 улирал/	Улсын тэргүүний сургууль, багш нарын арга туршлагатай танилцснаар	Багш нар туршлага солилцож мэдлэг ур чадвараа нэмэгдүүлнэ	Байгууллагын төсөв, орон нутгийн төсвийн дэмжлэг	Сургуулийн Захирал, сургалтын алба
14	Аймаг, сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 10 дахь заалт	1 дүгээр багийн цэцэрлэг, бага сургуулийн барилгын гүйцэтгэлийг хангаж, хашаа худаг цахилгааны эх үүсвэрийг шийдэж өдөр тутамын үйл ажиллагааг эхлүүлэх	Гүйцэтгэлийг хангуулан дэд бүтцийг шийдэж үйл ажиллагааг эхлүүлснээр	Бага насны хүүхдийн сурч хөгжих орчин бүрдэнэ	Орон нутгийн төсөв	Аймаг, сумын Засаг дарга

1	2	3	4	5	6	7
15	Аймаг, сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 12, 8 дахь заалт	“Сайн багш” “Сайн хичээл” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Багшийн ур чадвар дээшилж, сурлагын амжилт чанарт ахиц гаргаснаар	Сурлагын амжилт, чанарын үзүүлэлт ахисан байна	Байгууллагын төсөв	Сургуулийн захирал
16	Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 16,12 дахь заалт	“Робокон-Эрдэнэцогт” хөтөлбөр хэрэгжүүлэх	Өсвөрийн зохион бүтээгч клуб ажиллуулан, тэмцээн уралдаанд оролцуулснаар	Тэмцээн уралдаанд 1 доошгүй удаа оролцосон байна	Засаг даргын нөөц хөрөнгө	Сургуулийн захирал
17	Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 23,14 дахь заалт	“Хос бичигтэн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Ажлын төлөвлөгөөний биелэлт 90-с доошгүй хувьтай байна	Ажилтнуудын мэдлэг чадвар ахисан байна	Байгууллагын төсөв	Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Сургуулийн захирал
18	Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 17, 13 дахь заалт	“Сурагч бүр сурах бичигтэйгээ” хөтөлбөрийг дэмжиж үргэлжлүүлэх	Сурах бичгийн хангалтын хувииг 20 хувиар нэмэгдүүлсэн байх	Бага-202 Дунд-118 Ахлах- 67 хүргэнэ	Байгууллагын төсөв, төсөл хөтөлбөр	Сургуулийн захирал
19	Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр. БОЛОВСРОЛ 14	Эрдэнэцогт сумын сургуулийн дотуур байрны барилгад их засвар хийж, хүүхдийн сурч амьдарч буй орчныг камержуулах	Дотуур байрны барилгад их засвар хийж ашиглалтанд оруулан, сургууль дотуур байрны орчныг камержуулснаар	Дотуур байрны сурагчдад ая тухтай амьдрах орчин бүрдэн, хараа хяналт сайжирснаар	Орон нутгийн төсөв 160,0 сая	Аймаг, сумын Засаг дарга, Сургуулийн захирал
20	Аймгийн нийгэм эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	сургуулийн гаднах спорт тоглоомын талбай, хайс хашааг засварлана	Хөл бөмбөгийн талбайтай болж, орчныг засаж тохижуулснаар	Сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөн, бие бялдрыг хөгжүүлэх орчин бүрдэнэ	Аймгийн төсөв, байгууллагын нөөц	Сургуулийн захирал

1	2	3	4	5	6	7
В. ЭРҮҮЛ МЭНД Зорилго: Эрүүл амьдрах таатай боломжийг бүрдүүлсэн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлнэ.						
21	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 28 дэх заалт	“Элэг бүтэн Баянхонгор” болон “Халдварт өвчнөөс сэргийлэх хянах” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 90- ээс дээш хувьтай хэрэгжинэ.	Хүн амйн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүд өмнөх оноос ахисан байна.	Байгууллагын төсөв	Эрүүл мэндийн төвийн дарга Нийгмийн бодлогын мэргэжилтэн
22	Аймаг сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 29 дэх заалт	Эрүүл мэндийн боловсрол хөтөлбөр хэрэгжүүлж “Эрүүл сум, баг, байгууллага” болзолт уралдаанд оролцон дэмжигч байгууллагын тоог нэмэгдүүлнэ	Эрүүл мэндийн боловсрол олгох ажлын төлөвлөгөөний биелэлтийг 90-с дээш хувьд хүргэнэ	Иргэдийн эрүүл мэндийн боловсрол мэдлэг сайжирна	Байгууллагын төсөв	Эрүүл мэндийн төв Соёл, спортын төв Нийгмийн бодлогын мэргэжилтэн
23	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-Б-3 дэх заалт	“Идэвхтэй хөдөлгөөн-Урт нас” аяныг өрнүүлж аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчид ,иргэдийг өргөнөөр хамруулах	Халдварт бус өвчлөлийн түвшин буурна	Дасгал хөдөлгөөнөөр хичээллэгс- дийн тоо нэмэгдэнэ	Байгууллагын төсөв	Эрүүл мэндийн төв Соёл, спортын төв Нийгмийн хөгжлийн ажилтан
24	Аймаг сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 37 дахь заалт	Урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог бүх багийн түвшинд хийж, Нийт хүүхдийн 70 дээш хувийг шүдний эмгэг бууруулах урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж	Үзлэг оношилгоонд хамрагдсан иргэд, хүүхдийн тоо	Насанд хүрэгчид 800 хүн, 500 хүүхэд хамруулах	Байгууллагын төсөв	Эрүүл мэндийн төвийн дарга Сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч
25	Аймаг сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 36 дахь заалт	“Эрүүл мэндийн ажилтны хөгжил дэд хөтөлбөр” ийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Хөтөлбөр хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувиас дээш байна	Эмч ажилчдын ур чадвар мэдлэг хандлага сайжирсан байна.	Байгууллагын төсөв	Эрүүл мэндийн төвийн дарга

1	2	3	4	5	6	7
26	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөбөрийн 1-Б-1 дэх заалт	Хүн амын өвчлөл нас баралтанд нөлөөлж буй амьдралын буруу хэвшил, дадал хорт зуршлаас татгалзах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэхэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт зохион байгуулж, иргэдэд эрүүл зан үйлийг төлөвшүүлж ажиллах	Сургалт мэдээлэлд хамрагдан буруу хэвшил, дадал зуршлаас татгалзсан хүний тоогоор Сургалтанд 2000 иргэнийг хамруулсан байна.	Иргэд амьдралын буруу дадал зуршлаас татгалздаг болно. ИргэдиН эрүүл зан үйлийн төлөвшил сайжирна	Байгууллагын төсөв Байгууллага хөтөлбөр	Эрүүл мэндийн төвийн дарга Хамтарсан баг Нийгмийн эрүүл мэндийн ажилтан
27	Эрүүл мэндийн тухай хуулийн хээгжилтийг хангах ажлын хүрээнд	Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт 80 хувиас дээш байна	Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирна. Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилнэ	Байгууллагын төсөв	Эрүүл мэндийн төвийн дарга Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
28	Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөбөрийн 1-Б-8 дэх заалт	Ахмадын эмчилгээ, сувилгааны өрөөг бий болгож, өндөр настанд гэрээр үйлчлэх үйлчилгээг эрчимжүүлж хэвшүүлэх	Үйлчилгээ үзүүлсэн ахмадуудын тоогоор	Тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирна	Байгууллагын төсөв	Эрүүл мэндийн төвийн дарга
29	Эрдэнэцогт сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-Б-9	Эрүүл мэндийн төвд физик эмчилгээний тоног төхөөрөмжтэй болгох	Уламжлалт эмчилгээ хийх байр, тоног төхөөрөмж, мэргэжилтэнтэй болсноор	Уламжлалт эмчилгээгээр эмчлүүлэгчдийн тоо нэмэгдэж, эмийн эмчилгээний тоог багасгана.	Төсөл хөтөлбөр	Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн төвийн дарга

Г.СОЁЛ УРЛАГ, СПОРТ

Зорилго: Соёл урлаг, спортыг бүх талаар дэмжин хөгжүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

1	2	3	4	5	6	7
30	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 45 дахь заалт	Соёлын төвийн барилгыг шинээр барих	Соёл, спортын цогцолбор төв баригдаснаар	Соёл, олон нийтийн арга хэмжээний тав тухтай орчин бүрдэнэ	Улсын төсөв 1,6 тэрбум	ХОХБТХ Боловсрол соёл, урлагийн газар Соёл спортын төвийн эрхлэгч
31	Аймгийн Засаг даргын 2016-2020 он үйл ажиллагааны хөтөлбөр 41 дэх заалт	Эрдэнэцогт сум сурталчилах 3 хоногийг аймагт зохион байгуулах	Аймгийн хэмжээнд сумаа сурталчлах арга хэмжээг зохион байгуулснаар	Сум сурталчлах 3 хоног арга хэмжээг чанартай зохион байгуулсан байна	Орон нутийн төсөв	Сумын Засаг дарга, Соёл спортын төвийн эрхлэгч
32	Соёлын өвийг хамгаалах тухай хууль	Соёлын салбарт хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг хангах	Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг 80-с дээш хувьд хүргэнэ	Хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангагдана	Байгууллагын төсөв	Соёл, спортын төвийн эрхлэгч
33	Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-В-5	Үндэсний биеийн тамир спорт, соёл урлагийн ажлыг бололцоотой хэлбэрээр дэмжиж хөгжүүлэх	Сур, шагай, үндэсний бөх, морь бөх цоллооч, зэрэг уралдаан тэмцээн зохион байгуулагдаж, оролцогчдийн тоо өссөн байна	Хүүхэд залуучууд тухайн чиглэлээр бэлтгэгдэж ур чадвар нь нэмэгдэнэ	Байгууллагын төсөв	Соёл, спортын төвийн эрхлэгч
34	МУЗГ-ын 247 дугаар тогтоолоор батлагдсан "Журам батлах тухай"	"Угийн бичиг" хөтлөх сургалт хийж, сургалтын ахиц чанар үр дүнгийн тоог нэмэгдүүлэх	Өмнөх түвшнээс 15 хувиар нэмэгдүүлнэ	Иргэдийн ойлголт мэдлэг дээшилж угийн бичгээ хөтөлдөг болно	Байгууллагын төсөв	Соёл, спортын төвийн эрхлэгч
35	Сумын нийгэм эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Өөрийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж санхүүжилтийг 100 хувь хангаж ажиллах	Орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлж хэрэгцээт санхүүжилтийг шийдснээр	Өөрийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелүүлнэ	Үйл ажиллагаа	Соёл, спортын төвийн эрхлэгч
Д. НИЙГМИЙН ХАЛАМЖ ХАМГААЛАЛ						
Зорилго: Иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн нийгмийн халамж, хамгааллын оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ.						
36	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны	"Өрх толгойлсон эцэг эхийн	Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 80-аас	Ахмадууд, хөгжлийн бэршээлтэй	Халамжийн сан хандив тусламж	Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн

1	2	3	4	5	6	7
	хөтөлбөрийн 57,59,60 дахь заалт	нийгмийн хамгааллын хөтөлбөр, "Ахмадаа ачлая", хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "Тэгш дүүрэн" хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах	дээш хувьд хүргэнэ	иргэд, өрх толгойлсон эцэг, эхчүүдэд үзүүлэх дэмжлэг тусалцаа үйчилгээ сайжирна		Нийгмийн бодлогын мэргэжилтэн
37	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлөрийн 57 дахь заалт	Сум багийн түвшинд хамтарсан багийн дэмжлэг туслалцаа шаардлагатай ахмад настны нөхцөл байдлыг судлан тогтоож, хэрэгцээт дэмжлэг туслалцаа, үйлчилгээг тодорхойлж нийгмийн суурь үйлчилгээ үзүүлэх, төлөвлөгөө хэрэгжүүлнэ	Ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 80-аас дээш хувьтай байна.	Ахмад настанд тусламж үзүүлнэ.	Халамжийн сан Хандив тусламж	Нийгмийн бодлогын мэргэжилтэн Хамтарсан баг Багийн засаг дарга нар
38	Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-Г-5 дахь заалт	Өрхийн хөгжил –зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Зорилтот өрхийн хөгжил хамгааллын ажлын төлөвлөөний 2018 оны шалгуур үзүүлэлт хангагдана	Сонгогдсон өрхийн 60 хувьд ахиц өөрчлөлт гарсан байна	Төсөл хөтөлбөр	Хөдөлмөр эрхлэлт нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн
39	Аймаг, Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 64, 1-Г-4 дахь заалт	Малчдын Нийгмийн даатгалын сайн дурын даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрах хүрээг нэмэгдүүлэх	Сайн дурын даатгалд 90, Эрүүл мэндийн даатгал 90 хувьд хүргэх	Иргэдийг эрүүл мэнд нийгмийн даатгалд хамруулснаар	Иргэдийн нийгмийн хамгааллын баталгаа хангагдана	Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын байцаагч БЗД нар
40	Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйлажиллагааны хөтөлбөрийн 5.2.10 дахь заалт	Нэг иргэн- нэг бүртгэл үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Бүртгэлийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоогоор	Иргэний бүртгэл мэдээлэлсайжирна	Байгууллагын төсөв	Улсын бүртгэгч
41	Улсын бүртгэлийн тухай хууль, Хүн ам, орон сууцны тооллогын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд	Статистикийн хэлтсийн ХАӨМС, Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн мэдээллийн сангийн хүн амын зөрүүг арилгах	Бүртгэлийн үнэн зөв байдал хангагдснаар	Бүртгэлийн зөрүүтэй мэдээлэл арилсан байна.	Байгууллагын төсөв	Статистик хариуцсан мэргэжилтэн Улсын бүртгэгч

1	2	3	4	5	6	7
42	Аймаг, Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 66, 1-Г-6 дахь заалт	Нийгмийн 3 талт зөвшил хэлэлцээрийг байгуулан хэрэгжилтийг тооцож сумын хөгжилд төр, үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлэх	Зөвшилцөл хэлэлцээр байгуулж үр дүнг тооцноор	Хамтын ажиллагаа сайжирсан байна.	Байгууллага, оролцогч талууд	Хөдөлмөр эрхлэлт халамж хариуцсан мэргэжилтэн Нийгмийн бодлогын мэргэжилтэн Үйлдвэрчний эвлэл
Хоёр. Эдийн засгийн өсөлт үйлдвэр үйлчилгээ, бүтээн байгуулалт Зорилго: Эдийн засгийн хөгжлийг дэмжиж тогтвортой өсөлтийг ханган, дэд бүтэц үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлнэ.						
43	Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль, шилэн дансны тухай хууль, холбогдох тогтоол, шийдвэр журам	Орон нутгийн урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл тогтвортой, сахилга баттай санхүүгийн "Тунгалаг төсөв" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажилах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 95 хувьд хүргэнэ, Аудит, санхүүгийн хяналтаар илэрсэн алдаа зөрчлийг бууруулна, НББ хөтлөлтийг сайжруулна, ОНХС-ийн төлөвлөлт гүйцэтгэлийг сайжруулж, ХАА-г хуулийн дагуу зохион байгуулж хэвшинэ.	Санхүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирч, зөрчил дутагдал арилна.	Байгууллагын төсөв	Санхүүгийн албаны дарга
44	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 5 дугаар сарын 31 ний өдрийн "Журам батлах тухай" 276 дугаар тогтоол	Орон нутгийн өмчит бүх байгууллагуудын эзэмшлийн газар, хөрөнгийн дахин үнэлгээ хийгдэж, балансад бүрэн тусгаж, өмч хөрөнгийн хөдөлгөөнийг цахим програмаар явуулах	Программ ашиглалт 100 хувь болно	Орон нутгийн өмчит байгууллагуудын эзэмшлийн газар, хөрөнгийн үнэлгээ хийж тухайн байгууллагын санхүүгийн тайланд тусгана.	Байгууллагын төсөв	Орон нутгийн өмчийн газар Санхүүгийн албаны дарга, Нягтлан бодогч
45	Сумын Засаг даргын үйл ажиллагааны	Өрхийн мөнгөн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор	Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг	Ажлын байр бий болж, иргэдийн	Хувийн хөрөнгө оруулалт	Витафит ХХК Сумын Засаг дарга, УИХ-

1	2	3	4	5	6	7
	хөтөлбөрийн 2-1 дэх заалт	сүүний үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэн багийн малчдыг хамруулах	эхлүүснээр	орлого нэмэгдэнэ		ын гишүүн
46	Сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2,12 дахь заалт	Хот айл жуулчны бааз төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Малчдын нөхөрлөлийн үйлчилгээг өргөжүүлж үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх	Ажлын байр бий болж, малчдын орлого нэмэгдэнэ	Хувийн хөрөнгө оруулалт	Байгаль Орчны алба Малчдын бүлэг нөхөрлөлийн ахлагч
47	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2-13	Суманд амины орон сууц төсөл хэрэгжүүлэх	орон сууцны баригдсан байна	Иргэдийн амьдрах ая тухтай орчин бүрдэнэ	Хувийн хөрөнгө оруулалт	Сумын Засаг даргын Тамгын газрын дарга
48	Сумын нийгэм эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Эрдэнэцогт сумын хуучин нутгийн удирдлагын ордны барилгыг түрээсийн нөхцөлтэйгөөр ажиллуулах	Түрээсийн нөхцөлөөр ажиллуулснаар	Түрээсийн журам хэрэгжүүлнэ	Түрээслэгчдийн хувийн хөрөнгө	Засаг даргын Тамгын газрын дарга
49	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2,4 дэх заалт	Засгийн газрын 21-100 хөтөлбөрийн хүрээнд Чулууны үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх	Чулууны үйлдвэр байгуулагдснаар	Үйлдвэр бий болж ашиглалтанд орсон байна	Улсын төсөв 1.6 тэр бум	Аймаг, сумын Засаг дарга
50	Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 129 дэх заалт	Баянхонгор-Архангай аймгийн Цэцэрлэг хот чиглэлийн 210 км замыг улсын чанартай авто замын сүлжээнд оруулах ажлыг холбогдох газруудад хүргүүлэх	Баянхонгор-Архангай аймгийн Цэцэрлэг хот чиглэлийн замыг улсын чанартай авто замын сүлжээнд оруулж батлуулах Хоёр аймгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх.	Баянхонгор-Архангай аймгийн зам чиглэлийн зам улсын чанартай авто замын сүлжээнд орж батлагдсанаар	Байгууллагын төсөв	Аймаг, сумын Засаг дарга
51	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2,6 дахь заалт	Үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтцийг шийдвэрлэх /гүний худаг гаргах, цахилгааны шугам татах,	Шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх	Шаардлагатай дэд бүтцийг хийж гүйцэтгэнэ	Орон нутгийн хөгжлийн сан 15,0	Сумын Засаг дарга

1	2	3	4	5	6	7
52	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2,16 дахь заалт	Хатуу хучилттай 2 км зам тавьж эхлүүлнэ	Зам тавигдан дэд бүтцийг хөгжүүлснээр	Зорчих таатай боломж бүрдэнэ	Орон нутгийн төсөв 350,0	Аймаг, Сумын Засаг дарга
53	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн	Сумын төвийн зарим хэсэгт тохижилт чимэглэл хийж, гудамжны гэрэлтүүлгийг сэргээн засварлаж 70-н гэрлээр нэмэгдүүлнэ	Сумын өнгө үзэмжийг сайжруулна	Иргэд амьдрах таатай нөхцөл боломжоор хангагдана	Орон нутгийн хөгжлийн сан 10,0 сая	Сумын Засаг дарга Санхүүгийн албаны дарга
54	Сумын нийгэм эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Хогийн машины засвар үйлчилгээг хийж ажилд оруулах	Засвар үйлчилгээг бүрэн хийснээр	Хог тээвэрлэлтийн үйл ажиллагааг хангана	Байгууллагын төсөв 500,0	Санхүүгийн албаны дарга

Гурав. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Зорилго: Таваарлаг мал сүрэгтэй, эрчимжсэн газар тарианг хөгжүүлж ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

55	Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 102 дахь заалт	Монгол мал хөтөлбөрийн 2 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан үр дүнг тооцож ажиллах	Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 90-с доошгүй хувьд хүргэнэ	Мал аж ахуйн бүртгэл мэдээлэл сайжирна	Байгууллагын төсөв	Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга, мэргэжилтэн
56	Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 105 дахь заалт	Улсын мал эмнэлгийг хуулийн дагуу байгуулж, халдварт, халдварт бус өвчлөлөөс сэргийлэх, нийгмийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдлийг бууруулах зорилгоор ажиллуулах	Улсын мал эмнэлэг байгуулагдснаар	Мал сүргийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэж, нийгмийн эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг бууруулна	Улсын төсөв	ХХААГ, Сумын Засаг даргын Тамгын газар
57	сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3-12 дахь	“Өрхийн тариалан” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг хангаж,	Тариалалтыг эрчимжүүлэн, Үлийтэй тэмцэх ажил чанартай хийгдснээр	Иргэдийн хүнсний хангамж нэмэгдэнэ, 5000 гад үлий устгал хийсэн	Зохион байгуулалт, дэмжлэг	Мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтэн

1	2	3	4	5	6	7
	заалт	Бэлчээрийн хортонтой тэмцэх ажлыг малчдын оролцоотой зохион байгуулах		байна		Багийн Засаг дарга нар Тариаланчид
58	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 101,106 дахь заалт	Хөшөөгийн амны ногооны талбайд 3 га газарт тэжээлийн ургамал тариалах	Талбай бэлтгэн тэжээлийн ургамал тариалснаар	2-гад тэжээлийн ургамал тариалсан байна	Дотоод нөөц малчдын оролцоогоор	Мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга Багийн Засаг дарга нар Газрын даамал
59	Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 93 дахь заалт	Өвс тэжээлийн нөөц, бүрдүүлж малчид өөрсдийн малын тоонд тохирсон өвс тэжээл бэлтгэх ажлыг даалгавар болгон гүйцэтгүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-с дээш хувьд хүргэнэ	Өвс тэжээлийн нөөц бүрдүүлсэн байна	Өөрсдийн нөөц	МЭҮТ-ийн дарга БЗД нар
60	Аймгийн засаг даргын	Мал аж ахуйн гаралтай түүхий	Жижиг үйлдвэр байгуулах	Орон нутагт	Төсөл,	Мал эмнэлэг
	2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 78 дахь заалт	эд боловсруулах анхан шатны үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллуулах	эхлэл тавигдсанаар	ажлын байр бий болж бүтээгдэхүүн	хөтөлбөр Хувийн хөрөнгө	үржлийн тасгийн мэргэжилтэн
61	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3-11 дэх заалт	4,5 дугаар багт Мал тарилгын хашаа угаалгын ванн барих	Үйл ажиллагааны төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлнэ	Мал сүргийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Иргэдийн Оролцоо	Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга, Багийн Засаг дарга нар
62	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4-1	"Ногоон- Эрдэнэцогт хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд албан байгууллага аж ахуйн нэгж айл өрхийн хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх ажил зохион байгуулах	Хайлаас- 50 Улиас -50 Бургас -50 Шар хуайс-50	Ногоон байгууламж нэмэгдэнэ	ОНХСан төсөл хөтөлбөр	Байгаль орчны хяналтын улсын байцаагч

1	2	3	4	5	6	7
63	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 87 дахь заалт	Төсөл сонгон шалгаруулалтаар Бухтын аманд жуулчны бааз байгуулах	Жуулчны бааз байгуулагдснаар	Амралт аялал жуулчлалын орчин бүрдсэн байна	Төсөл хөтөлбөр, хувийн хөрөнгө	Байгаль орчин аялал жуулчлалын газар Байгаль орчны хяналтын улсын байцаагч
64	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4-2	Байгаль хамгаалах багц хуулийн хэрэгжилтийг ханган иргэдэд эрх зүйн боловсрол олгох, иргэний журамт үүргийг хангуулах ажил зохион байгуулна	1200иргэнийг хууль эрх зүйн сургалтанд хамруулсан байна.	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилж, байгаль орчноо хамгаалах идэвхийг нэмэгдүүлнэ	Байгууллалын төсөв	Байгаль орчны хяналтын улсын байцаагч Байгаль хамгаалагч нар
65	Амьтны тухай хуулийн 6.1.8	Зэрлэг ан амьтны идэш тэжээл хомсдож буй бүс нутагт био техникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Тэжээл хомсдож буй бүс нутагт биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ	Ан амьтан байрших нөхцөл боломж бүрдэнэ	Аймгийн БОХ сан	Байгаль орчин аялал жуулчлалын газар, Байгаль орчны хяналтын улсын байцаагч Байгаль хамгаалагч нар
66	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4-2	Сурагчдын экологийн боловсролыг дээшлүүлж, “Эко аялал” зохион байгуулна	Сурагчдын танин мэдэхүйн мэдлэг чадвар дээшилнэ	Хүүхдүүд байгаль орчноо судалж, хамгаалах идэвх сэргэнэ	Байгууллагын төсөв	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
67	Сумыг засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2-14	Нөмрийн өвөрт Түйн голын орчимд хөрсийг нөхөн сэргээх зорилгоор жимс жимсгэнэ мод тариалах төсөл сонгон шалгаруулж үр дүнтэй ажиллуулах	Төсөл сонгон шалгаруулж мод тариалснаар	Орчны хөрс хамгаалагдаж ногоон байгууламж нэмэгдэнэ	Хувийн хөрөнгө оруулалт	Байгаль орчны хяналтын улсын байцаагч Газрын даамал
68	Сумыг засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газрын альбом хийх	Зурагт альбом хийгдснээр	Түүх соёлын дурсгал, үзэсгэлэнт газрын альбомтой болсон байна	Байгууллагын төсөв	Засаг даргын орлогч Санхүүгийн албаны дарга

1	2	3	4	5	6	7
						Байгаль орчны хяналтын улсын байцаагч
69	Сумыг засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4-3 дахь заалт	Гудамж талбай, байгууллага орчны цэвэрлэгээ хийж, золбин нохой устгах ажлыг зохион байгуулна	Цэвэр цэмцгэр орчин бий болж, иргэдийн аюулгүй байдал хангагдана	Ая тухтай, амгалан орчин бүрдэнэ	Байгууллагын төсөв	Санхүүгийн алба Багийн Засаг дарга
70	Сумыг засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4-1 дахь заалт	Газрын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж, сургалт мэдээлэл хийж, газрын харилцаан дахь үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Иргэдийн газрын тухай хуулийн мэдлэг мэдээлэл сайжирсан байна	Газрын харилцааны талаарх иргэдийн эрхийг хангана	Байгууллагын төсөв	Газрын даамал
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛ, ГАДААД ХАРИЛЦАА, НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО						
Зорилго: Хууль дээдлэх ёсыг эрхэмлэн, иргэдийн аюулгүй байдлыг хангасан мэргэшсэн хариуцлагатай төрт ёсыг бэхжүүлнэ.						
71	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 144	Цахим хурлын тоног төхөөрөмжөөр ханган, сургалт, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр хийх	Тоног төхөөрөмжөөр хангагдсанаар	Хурал зөвлөгөөн, сургалт мэдээллийг цахимаар авах нөхцөл бүрдэнэ	Байгууллагын төсөв	ТЗУХ Тамгын газрын дарга
72	Цэргийн албаны тухай хууль	Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг зохион байгуулж, 1,2 дугаар зэргийн үүрэгтнүүдэд холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран сургалтанд хамруулна.	Цэргийн насны иргэдийн бүртгэл мэдээлэл хийгдсэн байна	Залуучууд бүртгэл Мэдээлэлд хамрагдан, мэдээллээр хангагдана	Байгууллагын төсөв	Засаг даргын Тамгын газрын дарга
73	Сумыг Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5-7 дахь заалт	Цэргийн дүйцүүлэх албаны иргэдийг сум орон нутгийн бүтээн байгуулалтын чанартай ажилд татан оролцуулж, нийтийг хамарсан хөдөлмөрт иргэд цэргийн насны залуусыг	Дүйцүүлэх албанд бүртгэлтэй иргэдийг сургалт мэдээллээр ханган, бүтээн байгуулалтын жилд оролцуулсан байна.	Дүйцүүлэх албанд бүртгэгдсэн иргэд бүрэн хамрагдаж, орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцсон байна	Байгууллагын төсөв	Засаг даргын Тамгын газрын дарга

1	2	3	4	5	6	7
79	Мэдээллийн ил тод байдал ба Мэдээлэл авах эрхийн тухай хууль	Төрийн байгууллагуудад Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж үйл ажиллагааг бүх талаар илтгэж ажиллах	Иргэдэд ил тод мэдээлэл хүрснээр	Иргэд мэдээллээр хангагдана	Байгууллагын төсөв	Засаг даргын Тамгын газрын дарга, Байгууллагын дарга эрхлэгчид
80	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 143 дахь заалт	Төрийн захиргааны албан хаагчдын ажлын үр дүнд үндэслэн "Сургалтын нэгдсэн төлөвлөгөө" гаргаж, хэрэгжилтийг хангах	Төлөвлөгөөний хэргэжилтийг 90-с дээш хувьд хүргэнэ	Төрийн албан хаагчид сургалт мэдээллээр хангагдана	Байгууллагын төсөв	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс Тамгын газрын дарга
81	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 144 дэх заалт	Төрийн байгууллагуудад хэрэгжүүлж буй "Байгууллагын дотоод удирдлагын систем"ийн ашиглалтыг сайжруулах	Сумын хэмжээнд системийн ашиглалтыг 90 хувьд хүргэнэ	Төрийн албан хаагчдын ажлын бүтээмж, байгууллагын дотоод үйл ажиллагаа хяналт удирдлагын нэгдсэн систем сайжирсан байна.	Байгууллагын төсөв	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс Тамгын газрын дарга, байгууллагын дарга эрхлэгчид
82	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 144 дэх заалт	Сум орон нутгийн онцлог ажлыг тогтмол сурталчлах, идэвхтэн сурвалжлагчдын үйл ажиллагааг сайжруулах	Цахим сүлжээнд тавигдсан мэдээ мэдээллийн тоо	Орон нутгийн ажил олон нийтэд ил тод нээлттэй болно	Байгууллагын төсөв	Тамгын газрын дотоод ажил харицсан мэргэжилтэн, Байгууллагын архив бичиг хэргийн ажилтнууд,
83	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 144 дэх заалт	Багийн Иргэдийн нийтийн хурал, нээлттэй хаалганы өдөрлөг, урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулах	Хамрагдсан иргэдийн тоо 1000 хүн	Иргэд мэдээ мэдээлэл авч, соёл урлагаар үйлчлүүлнэ	Байгууллагын төсөв	ИТХурлын ажлын алба Тамгын газар Соёл спортын төв
84	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 145 дахь заалт	Нутгийн удирдлагын ордонь засвар үйлчилгээ тохижилтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэлийг 100 хувь хангах	Тохижилт засвар үйлчилгээний гүйцэтгэл бүрэн хангагдсанаар	Ая тухтай тохилог орчин бүрдсэн байна	Гүйцэтгэгч компанийн хөрөнгө	Тамгын газрын дарга

1	2	3	4	5	6	7
85	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн	Нутгийн удирдлагын ордонь зоорийн давхарыг түшиглэн нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх фитнес клубыг байгуулж ажиллуулах	Фитнес клубыг байгуулснаар	Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх тухтай орчин бүрдэнэ	Байгууллагын төсөв	Тамгын газрын дарга
86	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн	Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийг шинэчлэн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Нутгийн зөвлөлийг шинэчилснээр	Нутгийн зөвлөл шинэчлэгдэн үйл ажиллагаа тогтмолжино	Байгууллагын төсөв	Сумын Засаг дарга
87	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5-1 дэх заалт	Төрийн албанд ажиллагсдыг сургаж дадлагажуулан мэргэшсэн албан хаагч болгон хөгжүүлэх, "Нийгмийн баталгаа хангах" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт 80 хувиас дээш хангагдана доошгүйд хүрснээр	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдана	Байгууллагын төсөв	Тамгын газрын дарга
88	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 151 дэх заалт	Гамшгийн эрсдлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Хөтөлбөрийн хэрэгжилт 80-с дээш хувьд хүрсэн байна.	Байгууллагын төсөв	ОБГ, Тамгын газрын дарга
89	Сумын нийгэм эдийн засагийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Мон-лаа ХК –ны өр авлагыг барагдуулах	Мон лаа ХК нь Эрдэнэцогт сумын 1200 гаруй иргэнд 96 сая төгрөгний өртэй, өрийг барагдуулах арга хэмжээ авах	1200 гаруй иргэний өр авлага барагдсанаар	Компаний хөрөнгө	Сумын Засаг дарга МОНЛАА-ХХК
90	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 153 дахь заалт	Өвөр Монголын өөртөө засах орны Альшаа, Шилэн гол зэрэг аймаг, Эзнээ хошуутай харилцан хамтран ажиллаж, Тооройн баяр зэрэг үйл ажиллагаанд малчид, бизнес эрхлэгчдийг оролцуулах ажлыг дэмжинэ.	Хамтын ажиллагааг хөгжүүлж бэхжүүлснээр	Хамтын ажиллагаа сайжирна	Хувийн хөрөнгө оруулалт	Гадаад харилцаа аялал жуулчлалын алба Тамгын газрын дарга